

ДОРНОД АЙМГИЙН ХЭРЛЭН СУМЫН ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН 12 ДУГААР СУРГУУЛИЙН 10 ДУГААР АНГИЙН СУРАГЧДААС АВАХ ГАЗАР ЗҮЙН АНГИ ДЭВШИХ ШАЛГАЛТЫН МАТЕРИАЛ

2024.06.05
Анги бүлэг.....

А хувилбар

Хугацаа 60 минут
Нэр:


Нэгдүгээр хэсэг

1. Дараах зурагт зурагзүйн дүрслэлийн аль аргыг ашигласан байна вэ? /1 оноо/




- A. Ареал
- B. Өнгөт дэвсгэр
- C. Ижил шугам
- D. Хөдөлгөөнт шугам
- E. Картодиаграмм

2. Вектор хэлбэрээр өгөгдсөн дүрслэлийг растер хэлбэрт зөв шилжүүлсэн зургийг олоорой. /2 оноо/




3. Даваа гэрээсээ номын сан орохоор болов. Хэрхэн очихоо Google earth ашиглан байршлаа хайж үзэхэд 1,9 км зайтай байсан учир явганаар явахыг сонгожээ. Google Earth-ээс Даваагийн хайсан хайлтын үйл явцыг зөв тэмдэглэснийг сонгоорой. /2 оноо/

- A. B. C. D. E.




4. Байрзүйн зургаас хөл бөмбөгийн талбай байгуулахад хамгийн тохиромжтой цэгийг сонгоно уу? /1 оноо/



- A. G цэг
- B. H цэг
- C. E цэг
- D. K цэг
- E. F цэг

5. Манай галактикийг юу гэж нэрлэдэг вэ? /1 оноо/

- A. Маралын Гялаан
- B. Нарны аймаг
- C. Сүүн зам
- D. Андромеда
- E. Хөхдэй мэргэн



6. 6-р сарын 22-ны "Нар буцах өдөр" үд дундын нар ямар өргөрөг дээр эгц тусах вэ? /1 оноо/

- A. Хойд туйл
- B. Матрын зам
- C. Экватор
- D. Мэлхийн зам
- E. Өмнөд туйл

7. Туйлын азимут тусгагаар зурагдсан цагийн бүсийн зураг өгөгджээ. E цэг дээр хэдэн цагийн дараа нар жаргах вэ? /2 оноо/



- A. 12 цагийн дараа
- B. 6 цагийн дараа
- C. 2 цагийн дараа
- D. 4 цагийн дараа
- E. 3 цагийн дараа

8. гараг нарнаас 778 сая км зайд алслагдсан байдаг. Энэ зайг одон орны нэгжээр илэрхийлнэ үү. /2 оноо/

- A. Бархасбадь, 0.19 о.о.н
- B. Ангараг, 51.8 о.о.н
- C. Дэлхий, 1.00 о.о.н
- D. Бархасбадь, 5.19 о.о.н
- E. Ангараг, 5.19 о.о.н

9. Дэлхий дээрх хоёр цэгийн хоорондох хамгийн богино буюу дөт агаарын зам нь дэлхийн бөмбөрцгийн их тойргийн нумын дагуу тодорхойлогдоно. Лос-Анжелос хотоос Сөүл хот руу шууд нислэг хийхэд аль зүг рүү хөөрвөл илүү дөт зам байх вэ? /2 оноо/



- A. Зүүн өмнөд зүг рүү В. Зүүн хойд зүг рүү С. Баруун өмнөд зүг рүү
 D. Баруун хойд зүг рүү Е. Өмнөд зүг рүү

10. Хүн амын тоог нутаг дэвсгэрт нь харьцуулсан харьцааг гэнэ. /1 оноо/

- A. Хүн амын байршил В. Хүн амын шилжилт С. Хүн амын нягтшил
 D. Хүн амын нутагшилт Е. Хүн амын өсөлт


11. Антарктидад хүн ам маш бага тархан суурьшсан шалтгааныг сонгоно уу? /2 оноо/

- A. Жилд унах хур тунадас нь 2000мм-ээс дээш нутаг
 B. Далайн хүйтэн урсгалын нөлөөнд оршдог нутаг
 C. Хамгийн дулаан сарын температур нь +20°C-аас дээш нутаг
 D. Хөрсний бүтэц сайн, эрдэс бодисоор элбэг нутаг
 E. Гадаргын өндөр нь д.т.д 6000м-ээс дээш өндөртэй нутаг

12. Монгол улсын нутаг дэвсгэрийн хэмжээ 1564116 км² ба 2010 онд 2700000 хүн амтай байсан бол хүн амын нягтшилыг олно уу? /2 оноо/

- A. 1,3 B. 0,4 C. 1,5 D. 1,7 E. 2,1

13. Чулуулгийн үе давхарга тектоник хөдөлгөөний улмаас цуурч зөрдөг. Зурагт үзүүлсэн зөрөгт хөдөлгөөний доош суусан хэсгийг зөв нэрлэснийг сонгоорой. /1 оноо/



- A. Атираат уулс
 B. Горст
 C. Антиклиналь
 D. Синклиналь
 E. Грабен

14. Тунамал чулуулаг аль нь вэ? /1 оноо/

- A. Гнейс B. Галт уулын шил C. Гангиг D. Боржин E. Шохойн чулуу

15. Өмнөд Америкийн Андын нуруу тектоникийн хавтангийн ямар хөдөлгөөнөөр үүссэн бэ? /1 оноо/

- A. Зөрөгт B. Холдон салах C. Шилжин зөрөх D. Ойртон нийлэх E. Атирааших

16. Гаити улсад болсон газар хөдлөлтөөр олон байшин барилга нурж, ангал үүсэн газар доорх хоолой эвдэрч, мод ганхаж хугарчээ. Хэдэн баллын хүчтэй газар хөдлөлт болсныг тодорхойлно уу. /2 оноо/

- A. IV балл B. VIII балл C. VI балл D. X балл E. III балл

17. Бат нэгэн чулуугаар байшингийнхаа шатыг хийжээ. Ямар чулууг сонгосон гэж чи бодож байна вэ? /2 оноо/

- A. Боржин B. Шохойн чулуу C. Диорит D. Шаварлаг занар E. Пемза

18. Африк болон Евразийн хавтангууд 1 жилд 5 см орчим ойртон нийлдэг бол 1 сая жилийн дараа хэдэн км зайтай ойртохыг тооцоолно уу. /2 оноо/

- A. 0.5 км B. 500 км C. 5000 км D. 50 км E. 5 км

19. Дэлхийн гадаад буюу экзоген хүч нь нарны энерги ба хүндийн хүчний нөлөөгөөр үүснэ.

Асуултын тэмдгийн оронд аль нь тохирох вэ? /2 оноо/



- A. Тектоник хөдөлгөөн
 B. Газар хөдлөлт
 C. Галт уулшил
 D. Цунами
 E. Салхины үйл ажиллагаа

20. Бал чулуулгийн хатуулаг нь 1, бадмааргийн хатуулаг 9. Бал чулуу нь зөөлөн тул бадмаараг дээр зураас гаргадаг. Тэгвэл хээрийн жонш дээр зураас гаргахын тулд алийг нь сонгох вэ?

/2 оноо/

- A. Молор B. Кварц C. Алатит D. Бадмаараг E. Алмаз

21. Исланд улс нь олон тооны халуун булаг оргилон гарах гейзерээрээ алдартай бөгөөд, амралт рекреацийн энэ нөөц жуулчдыг татах хүчин зүйл болдог. Газрын гүний дулааныг эрчим хүчиндээ ашиглахаас гадна, жилийн турш хүлэмжийн тариалалт эрхлэх боломж бүрддэг байна. Эдгээрт нөлөөлсөн байгалийн хүчин зүйлийг сонгоно уу. /2 оноо/


- A. Хойд Америкийн ба Евразийн хавтангийн ойртон нийлэх хөдөлгөөн
 B. Африкийн хавтан ба Ираны хавтангийн ойртон нийлэх хөдөлгөөн

- C. Африкийн хавтан ба Ираны хавтангийн холдон салах хөдөлгөөн
- D. Хойд Америкийн ба Евразийн хавтангийн холдон салах хөдөлгөөн
- E. Сан- Андреасын зөрөг ба Карибын хавтангийн ойртон нийлэх хөдөлгөөн

22. Аль нь газрын гадарга дээр үүсдэг тунадасны төрөл вэ? /1 оноо/

- A. Цас B. Бороо C. Шүүдэр D. Мөндөр E. Нойтон цас

23. Дэлхийн дулааны бүслүүрийн зургийг ажиглан туйл талаасаа хамгийн дулаан сарын $+10^{\circ}\text{C}$ -ийн изотермээр зааглагдаж буй бүслүүрийг нэрлээрэй. /1 оноо/



- A. Сэрүүн бүслүүр
- B. Халуун бүслүүр
- C. Хүйтэн бүслүүр
- D. Мөнх хүйтний бүслүүр
- E. Өндөр уулын бүслүүр

24. Агаарын ижил температуртай цэгүүдийг холбосон шугамыггэнэ. /1 оноо/

- A. Изотерм B. Изокол C. Изогипс D. Изобар E. Изобат


25. Цаг агаар, уур амьсгалын бүх үзэгдэл явагддаг агаар мандлын үеийг сонгоно уу. /1 оноо/

- A. Давхраат мандал B. Дунд мандал C. Халуун давхраа
- D. Орчих мандал E. Гадаад мандал

26. Экватор орчмын далайн гадарга $+27^{\circ}\text{C}$ - ээс дээш халах үед ихэвчлэн үүсдэг тропикийн циклоныг сонгоно уу. /1 оноо/

- A. Торнадо B. Бриз C. Фён D. Пассат E. Уул хөндийн

27. Агаарын бага даралттай хэсгийн төлөв байдлын мэдээнээс зөвийг нь сонгоно уу. /1 оноо/



- A. Даралт 925 гПа
- B. Тэнгэр цэлмэг
- C. Дуу цахилгаантай
- D. Бороотой
- E. Температур -11°C

28. Аль нь эсрэг циклоны шинж вэ? /1 оноо/

- A. Хур тунадас орохгүй B. Тэнгэр бүрхэг C. Салхитай
- D. Төвдөө бага даралттай E. Агаарын хөөрөх хөдөлгөөн



29. Ойсон цацрагийн хэмжээг хувиар (%) илэрхийлдэг бөгөөд үүнийг гэнэ. /1 оноо/

- A. Шулуун цацраг B. Сарнисан цацраг C. Альбеда
- D. Нийлмэл цацраг E. Урт долгионт цацраг

30. Дээд мандлын үүл аль нь вэ? (1 оноо)

- A. Борооны бөөн B. Давхраат бөөн C. Сэмжин давхраат
- D. Өндрийн бөөн E. Давхраат

31. Өмнөд хагасын пассат салхины чиглэлийг сумаар харуулсан байна. Кориолисийн хүчний дагуу салхины чиглэл хэрхэн даялахыг зөв харуулсан хариуг олно уу. (1 оноо)



A




B



C




D



E

32. Далайн хэсгүүдийг тэмдэглэсэн зурагт Мексикийн буланг хэдийн тоогоор илэрхийлсэн байна вэ? /1 оноо/



- A. 4
- B. 2
- C. 1
- D. 3
- E. 5

33. Туул гол Хэнтий нурууны өвөр (д.т.д 1850 м)-өөс эх авч 819 км урсаад Орхон гол (д.т.д 780м)-д цутгадаг бол голын уналыг тооцоолно уу. $(H=H_1-H_2)$ /2 оноо/

- A. 2630 м
- B. 1031 м
- C. 1599 м
- D. 1070 м
- E. 2669 м

34. Дараах зураг нь байгальд ээлтэй ямар технологийг харуулсан байна вэ? (2 оноо)




- A. Ахуйн хэрэглээний усыг цэвэршүүлэх
- B. Гүний ус ашиглах
- C. Дээвэрт нарны зай хураагуур тавих
- D. Хиймэл бороо оруулах
- E. Борооны усыг хурааж, ашиглах

35. Амьд организмуудын амьдралын бүлгэмдлээс ургамал ба орчны нэгдлийг юу гэж нэрлэдэг вэ? /1 оноо/

- A. Зооценоз
- B. Биоценоз
- C. Фитоценоз
- D. Биотоп
- E. Микробиоценоз

36. ГУРВАЛЖИН ДИАГРАММЫГ ашиглан Р үсгээр тэмдэглэсэн цэг дээрх хөрсний бүтцийг зөв тодорхойлж, ямар төрлийн хөрс болохыг нэрлээрэй. /2 оноо/



- A. Элс-80%, шавар-10%, тоос- 10%, Нарийн элсэн хөрс
- B. Элс-90%, шавар-20%, тоос-10% Элсэнцэр хөрс
- C. Элс-70%,шавар-20%, тоос-10% Шавранцар хөрс
- D. Элс-10%, шавар-10%, тоос- 80% Хөнгөн шавранцар хөрс
- E. Элс-20%, шавар-10%, тоос-70% Элсэрхэг шавар хөрс

37. Дараах өгүүлбэрийн хоосон зайд тохирох үгсийг сонгоно уу. /2 оноо/


(1) бохирдол гэдэгт эвгүй үнэр, амт орж, өнгө өөрчлөгдөх, үүнээс үүдэн гарсан бүх үр дагаврыг хамруулж ойлгоно. Энэ нь (2) ба (3) гэсэн хоёр хэлбэрээр үүснэ. Ганга, Рейн, Темза зэрэг (4) нь хамгийн их бохирдолтой байна.

- A. (1) Хөрсний, (2) ургамлын, (3) чулуулгийн, (4) уулс
- B. (1) Эрдэс чулуулгийн, (2) дотоод, (3) гадаад, (4) нуурууд

- C. (1) Агаарын, (2) гадаад, (3) дотоод, (4) тэгш өндөрлөгүүд
 D. (1) Хотын, (2) дуу чимээ, (3), замын түгжрэл, (4) нуурууд
 E. (1) Усны, (2) ил, (3) далд, (4) голууд

Хоёрдугаар хэсэг

2.1 Дугуй диаграммыг ашиглан асуултад хариулаарай. /3 оноо/



A. Ямар гарал үүсэлтэй чулуу хамгийн бага хувийг эзэлж байна вэ?

B. Тунамал гаралтай чулуулгийн төрлүүдээс нэрлэнэ үү.

C. Тунамал гаралтай чулуулгийн онцлог шинжийг тодорхойлоорой.


2.2 Хурган нуураас зүүн хойш Ховд голын баруун талд орших Ховд (д.т.д 2737 м) уулын оройд агаарын температур $+10^{\circ}\text{C}$ байх үед уулын бэл (д.т.д 1737 м)-д хэдэн хэм байх вэ? /4 оноо/

Агаарын температур 100 м өндөрсөх тутамд 0.6°C -ээр буурна.

A. Агаарын температур $[ab]^{\circ}\text{C}$ /2 оноо/

B. Харьцангуй өндрийг бодож олоорой. $[cdef]$ м /2 оноо/

2.3 Завхан гол Отгонтэнгэр уулын өвөр д.т.д 2129 м өндөртэй хэсгээс эх авч 808 км урсаад д.т.д 1030 м өндөртэй Айраг нуурт цутгадаг. Өгөгдлийг ашиглан даалгаврыг гүйцэтгээрэй. /3 оноо/



A. Голын уналыг тооцоолоорой. $[abcd]$ м /1 оноо/

B. Голын хэвгийг тооцоолоорой. $[e,fg]$ м/км /2 оноо/

ДОРНОД АЙМГИЙН ХЭРЛЭН СУМЫН ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН 12 ДУГААР СУРГУУЛИЙН
10 ДУГААР АНГИЙН СУРАГЧДААС АВАХ ГАЗАР ЗҮЙН АНГИ ДЭВШИХ ШАЛГАЛТЫН МАТЕРИАЛ


2024.06.05
Анги бүлэг.....

В хувилбар

Хугацаа 60 минут
Нэр:


Нэгдүгээр хэсэг

1. Дараах зурагт зурагзүйн дүрслэлийн аль аргыг ашигласан байна вэ? /1 оноо/



- A. Ижил шугам
- B. Өнгөт дэвсгэр
- C. Картодиаграмм
- D. Хөдөлгөөнт шугам
- E. Цэгийн арга


2. Растер хэлбэрээр өгөгдсөн дүрслэлийг вектор хэлбэрт зөв шилжүүлсэн зургийг сонгоорой. /2 оноо/



3. Содоо сургуулиасаа шинэ сургалтын төв рүү явахаар болов. Хэрхэн очихоо Google earth ашиглан байршлаа хайж үзэхэд 4.5 км зайтай байсан учир дугуйгаар явахыг сонгожээ. Google Earth-ээс Содоогийн хайсан хайлтын үйл явцыг зөв тэмдэглэснийг сонгоорой. /2 оноо/

<p>File Edit View Tools Add</p> <p>Search</p> <p>Get Directions History</p> <p>A: Сургууль</p> <p>B: Сургалтын төв</p> <p>Get Directions</p> <p>United 45 km, 45 min</p>	<p>File Edit View Tools Add</p> <p>Search</p> <p>Get Directions History</p> <p>A: Сургалтын төв</p> <p>B: Сургууль</p> <p>Get Directions</p> <p>United 25 km, 45 min</p>	<p>File Edit View Tools Add</p> <p>Search</p> <p>Get Directions History</p> <p>A: Сургууль</p> <p>B: Сургалтын төв</p> <p>Get Directions</p> <p>United 45 km, 25 min</p>	<p>File Edit View Tools Add</p> <p>Search</p> <p>Get Directions History</p> <p>A: Сургууль</p> <p>B: Сургалтын төв</p> <p>Get Directions</p> <p>United 4.5 km, 25 min</p>	<p>File Edit View Tools Add</p> <p>Search</p> <p>Get Directions History</p> <p>A: Сургууль</p> <p>B: Сургууль</p> <p>Get Directions</p> <p>United 25 km, 45 min</p>
--	--	--	---	---

4. Байрзүйн зургаас одон орны оргил байгуулахад хамгийн тохиромжтой цэгийг сонгоно уу. /1 оноо/
 A. G цэг




- B. E цэг
- C. H цэг
- D. K цэг
- E. F цэг

5. Манай галактик ямар хэлбэртэй вэ? /1 оноо/

- A. Зууван
- B. Зөв биш
- C. Дугуй
- D. Мушгиа
- E. Цацарсан

6. 12-р сарын 22-ны "Ес эхлэх өдөр" үд дундын нар ямар өргөрөг дээр эгц тусах вэ? /1 оноо/



- A. Экватор
- B. Мэлхийн зам
- C. Матрын зам
- D. Хойд туйл
- E. Өмнөд туйл

7. Туйлын азимут тусгагаар зурагдсан цагийн бүсийн зураг өгөгджээ. С цэг дээр хэдэн цагийн дараа нар жаргах вэ? /2 оноо/



- A. 2 цагийн дараа
- B. 4 цагийн дараа
- C. 9 цагийн дараа
- D. 12 цагийн дараа
- E. 8 цагийн дараа

8. гараг нарнаас 58 сая км зайд алслагдсан байдаг. Энэ зайг одон орны нэгжээр илэрхийлнэ үү. /2 оноо/

- A. Дэлхий, 92 о.о.н
- B. Буд, 0.39 о.о.н
- C. Сугар, 39 о.о.н
- D. Буд, 2.58 о.о.н
- E. Дэлхий, 1.00 о.о.н

9. Дэлхий дээрх хоёр цэгийн хоорондох хамгийн богино буюу дөт агаарын зам нь дэлхийн бөмбөрцгийн их тойргийн нумын дагуу тодорхойлогдоно. Токио хотоос Нью-Йорк хот руу шууд нислэг хийхэд аль зүг рүү хөөрвөл илүү дөт зам байх вэ? /2 оноо/



- A. Баруун өмнөд зүг рүү
- B. Баруун хойд зүг рүү
- C. Зүүн өмнөд зүг рүү
- D. Зүүн хойд зүг рүү
- E. Баруун зүг рүү

10. Хүн ам байшин, барилга, гэр, майхан зэрэг янз бүрийн хэлбэр, зориулалттай орон байранд суурьших нутаг дэвсгэрийн зохион байгуулалтыггэнэ. /1 оноо/

- A. Хүн амын байршил
- B. Хүн амын шилжилт
- C. Хүн амын нягтшил
- D. Хүн амын нутагшилт
- E. Хүн амын өсөлт


11. Баруун Европын бүс нутагт хүн ам маш ихээр тархан суурьшсан шалтгааныг сонгоно уу. /2 оноо/

- A. Далайн дулаан урсгал дайран өнгөрөх нутаг
- B. Жилд унах хур тунадас нь 200 мм-ээс бага нутаг
- C. Хамгийн дулаан сарын температур нь +100С-аас бага нутаг
- D. Хөрсний бүтэц муу, эрдэс бодисоор бага нутаг
- E. Гадаргын өндөр нь д.т.д 6000 м-ээс дээш өндөртэй нутаг

12. Монгол улсын нутаг дэвсгэрийн хэмжээ 1564116 км² ба 1918 онд 647500 хүн амтай байсан бол хүн амын нягтшилыг олно уу. /2 оноо/

- A. 1,7
- B. 0,4
- C. 1,5
- D. 0,1
- E. 2,1

13. Чулуулгийн үе давхарга тектоник хөдөлгөөний улмаас цуурч зөрдөг. Зурагт үзүүлсэн зөрөгт хөдөлгөөний улмаас дээш өргөгдсөн хэсгийг зөв нэрлэснийг сонгоорой. /1 оноо/



- A. Синклиналь
- B. Грабен
- C. Антиклиналь
- D. Горст
- E. Тал газар

14. Магмын чулуулаг аль нь вэ? /1 оноо/

- A. Шохойн чулуу
- B. Гангиг
- C. Шаварлаг занар
- D. Галт уулын шил
- E. Хөрсөн чулуу

15. Сан Андреасын зөрөг тектоникийн хавтангийн ямар хөдөлгөөнөөр үүссэн бэ? /1 оноо/

- A. Холдон салах
- B. Шилжин зөрөх
- C. Ойртон нийлэх
- D. Уул үүсэх
- E. Атирааших

16. Байгаль нуурын орчим болсон газар хөдлөлтийг бүх хүн мэдэрч цонхны шил, сав суулга хагарч, байшингийн доторх шавардлагууд хуурчээ. Хэдэн баллын хүчтэй газар хөдлөлт болсныг тодорхойлно уу. /2 оноо/

- A. IX балл
- B. VI балл
- C. XII балл
- D. IV балл
- E. II балл

17. Дорж зуслангийн байшингаа өнгөлөхөөр болжээ. Ямар чулуулгийг сонговол гоёмсог, бат бөх болох вэ? /2 оноо/

- A. Хүрмэн чулуу
- B. Гангиг
- C. Жонш
- D. Гялтгануур
- E. Гнейс

18. Өмнөд Америкийн хавтан, Африкийн хавтангаас 1 жилд 4 см-ээр холдон салдаг бол 1 сая жилийн дараа хэдэн км-ийн зайтай холдохыг тооцоолно уу. /2 оноо/

- A. 4000 км
- B. 4 км
- C. 400 км
- D. 40 км
- E. 0.4 км

19. Дэлхийн дотоод буюу эндоген хүчний нөлөөгөөр доорх үзэгдлүүд явагдана. Асуултын тэмдгийн оронд аль нь тохирох вэ? /2 оноо /



- A. Өгөршил
- B. Чулуулаг
- C. Галт уулшил
- D. Эвдрэх, зөөгдөх
- E. Нар, салхины үйл ажиллагаа

20. Бал чулуулгийн хатуулаг нь 1, бадмааргийн хатуулаг 9. Бал чулуу нь зөөлөн тул бадмаараг дээр зураас гаргадаг. Тэгвэл хайлуур жонш дээр зураас гаргахын тулд алийг нь сонгох вэ? /2 оноо/

- A. Апатит
- B. Кварц
- C. Молор
- D. Гөлтгөнө
- E. Бадмаараг

21. Карибын тэнгисийн орнуудад болсон томоохон газар хөдлөлтийн мэдээллийг хүснэгтэд үзүүлээ. Газар хөдлөлийн шалтгааныг тодорхойлно уу. /2 оноо/

Он	Байршил	Магнитут
1902	Гватемал	7.5
1918	Пуэрто Рико	7.5
1946	Доминиканы БНУ	8.0
1985	Мексик	8.0
2001	Эл Сальвадор	7.7


- A. Энэтхэг- Австралийн хавтан ба Карибын хавтангийн холдон салах хөдөлгөөн
- B. Карибын хавтан ба Филиппинийн хавтангийн ойртон нийлэх хөдөлгөөн

- C. Карибын хавтан ба Евразийн хавтангийн ойртон нийлэх хөдөлгөөн
- D. Ираны хавтан ба Карибын хавтангийн шилжин зөрөх хөдөлгөөн
- E. Хойд Америкийн хавтан ба Карибын хавтангийн ойртон нийлэх хөдөлгөөн

22. Аль нь үүлнээс унадаг тунадасны төрөл вэ? /1 оноо/

- A. Хяруу
- B. Шүүдэр
- C. Манан
- D. Бороо
- E. Цан

23. Дэлхийн дулааны бүслүүрийн зургийг ажиглан хоёр талаасаа $+20^{\circ}\text{C}$ -ийн изотермээр зааглагдаж буй бүслүүрийг нэрлээрэй. /1 оноо/



- A. Өндөр уулын бүслүүр
- B. Сэрүүн бүслүүр
- C. Хүйтэн бүслүүр
- D. Мөнх хүйтний бүслүүр
- E. Халуун бүслүүр

24. Агаарын ижил даралттай цэгүүдийг холбосон шугамыггэнэ. /1 оноо/

- A. Изобар
- B. Изокол
- C. Изотерм
- D. Изогипс
- E. Изобат


25. Нарны хэт ягаан туяаг шингээдэг, озон их хэмжээтэй агуулагддаг, агаар мандлын үеийг сонгоно уу. /1 оноо/

- A. Халуун давхраа
- B. Орчих мандал
- C. Давхраат мандал
- D. Дунд мандал
- E. Гадаад мандал

26. Экватор орчмын далайн гадарга $+27^{\circ}\text{C}$ - ээс дээш халах үед ихэвчлэн үүсдэг, тропикийн циклоныг сонгоно уу. /1 оноо/

- A. Бриз
- B. Тайфун
- C. Фён
- D. Пассат
- E. Муссон

27. Агаарын бага даралттай хэсгийн төлөв байдлын мэдээнээс зөвийг нь сонгоно уу. /1 оноо/



- A. Температур -11°C
- B. Дуу цахилгаантай
- C. Тэнгэр бүрхэг
- D. Бороотой
- E. Салхи зүүнээс

28. Аль нь циклоны шинж вэ? /1 оноо/

- A. Тэнгэр цэлмэг
- B. Шуургатай
- C. Төвдөө их даралттай
- D. Агаарын уруудах хөдөлгөөнтэй
- E. Хур тунадасгүй

29. Нарны нийлмэл цацрагийг аль нь зөв тодорхойлсон бэ? /1 оноо/

- A. Нийлмэл цацраг = ойсон цацраг + угтах цацраг
- B. Нийлмэл цацраг = шингэсэн цацраг + шулуун цацраг
- C. Нийлмэл цацраг = ашигтай цацраг + алдагдах цацраг
- D. Нийлмэл цацраг = шингэсэн цацраг + сарнисан цацраг
- E. Нийлмэл цацраг = шулуун цацраг + сарнисан цацраг


30. Аль үүлнээс хур тунадас орох вэ? /1 оноо/

- A. Сэмжин
- B. Сэмжин бөөн
- C. Өндрийн бөөн
- D. Борооны давхраат
- E. Өндрийн давхраат


31. Хойд хагасын пассат салхины чиглэлийг сумаар харуулсан байна. Кориолисийн хүчний дагуу салхины чиглэл хэрхэн даялахыг зөв харуулсан хариуг олно уу. /1 оноо/




A




B



C



D



E

32. Далайн хэсгүүдийг тэмдэглэсэн зурагт Бенгалын буланг хэдийн тоогоор илэрхийлсэн байна вэ? /1 оноо/




- A. 2
- B. 1
- C. 3
- D. 4
- E. 5

33. Орхон гол Хангай нурууны Суваргахайрхан уул (д.т.д 3021 м) -аас эх авч 1124 км урсаад Сэлэнгэ мөрөн (д.т.д 601 м) -д цутгадаг бол голын уналыг тооцоолно уу. (H=N1-H2) /2 оноо/

- A. 3622 м B. 1897 м C. 1725 м D. 2420 м E. 4145 м

34. Дараах зургийг ажиглаад 2000-2015 оны хооронд нуурын талбай, тоо хэрхэн өөрчлөгдөж байгааг тодорхойлно уу. (2 оноо)




- A. Нийт нуурын талбай болон ширгэсэн нуурын тоо ихэсч байна.
- B. Нийт нуурын талбай багасч, ширгэсэн нуурын тоо ихэсч байна.
- C. Нийт нуурын талбай ихэсч, ширгэсэн нуурууд сэргэсэн.
- D. Нийт нуурын талбай болон ширгэсэн нуурын тоо багассан.
- E. Нийт нуурын талбай ихэсч, ширгэсэн нуурын тоо багассан.

35. Нэгэн төрлийн орчинд орших ургамал, амьтан, бичил биетийн харилцан холбооны нэгдлийг гэнэ. /1 оноо/

- A. Экоцистем B. Биотоп C. Микроценоз
- D. Биоценоз E. Экотоп

36. ГУРВАЛЖИН ДИАГРАММЫГ ашиглан Н үсгээр тэмдэглэсэн цэг дээрх хөрсний бүтцийг зөв тодорхойлж, ямар төрлийн хөрс болохыг нэрлээрэй. /2 оноо/

- A. Элс-80%, шавар-10%, тоос-20% Шавранцар хөрс
- B. Элс-20%, шавар-20%, тоос-60% Хөнгөн шавранцар хөрс
- C. Элс-80%, шавар-30%, тоос-50% Элсэнцэр хөрс
- D. Элс-30%, шавар-50%, тоос-20% Шаварлаг хөрс
- E. Элс-30%, шавар-20%, тоос-50% Тоосорхог хөрс




37. Дараах өгүүлбэрийн хоосон зайд тохирох үгсийг сонгоно уу. /2 оноо/

- (1) жигд бус, дэлхийн гадаргын (2), (3) зүй тогтлоос хамаардаг бөгөөд энэ нь
 (4) ялгах үндсэн шинж болно.
- A. (1) Гадаргын ус, (2) эрдэс, (3) чулуулгийн, (4) уур амьсгалын бүсийг
 B. (1) Ойн тархалт, (2) чийг, (3) дулааны, (4) байгалийн бүсийг
 C. (1) Эрдэс чулуулгийн тархалт, (2) дотоод, (3) бүтцийн, (4) нар гийгүүлэх хугацааг
 D. (1) Цөлийн тархалт, (2) рельеф, (3) далайн дулаан урсгалын (4) өндрийн бүслүүрийг
 E. (1) Хур тунадасны хуваарилалт, (2) эх чулуулаг, (3), амьтны, (4) далайн урсгалыг

Хоёрдугаар хэсэг

2.1 Дугуй диаграммыг ашиглан асуултад хариулаарай. /3 оноо/



A. Ямар гарал үүсэлтэй чулуу хамгийн их хувийг эзэлж байна вэ?

B. Магмын гаралтай чулуулгийн төрлүүдээс нэрлэнэ үү.

V. Магмын гаралтай чулуулгийн онцлог шинжийг тодорхойлоорой.


2.2 Сүхбаатар аймгийн Дарьганга сумын нутагт орших Шилийн Богд (д.т.д 1778 м) уулын бэлд (д.т.д 1278 м) агаарын температур +20°C байх үед уулын оройд хэдэн хэм байх вэ?/4 оноо/

Агаарын температур 100 м өндөрсөх тутамд 0.6°C-ээр буурна.

A. Агаарын температур [ab]°C /2 оноо/

V. Харьцангуй өндрийг бодож олоорой. [cde] м /2 оноо/

2.3 Хэрлэн гол Хэнтийн нурууны өвөр д.т.д 1750 м өндөртэй хэсгээс эх авч 1382 км урсаад д.т.д 625 м өндөртэй Далай нуурт цутгадаг. Өгөгдлийг ашиглан даалгаврыг гүйцэтгээрэй.



i. Голын уналыг тооцоолоорой. [abcd] м /1 оноо/

ii. Голын хэвгийг тооцоолоорой [e.f] м/км /2 оноо/